



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

Аймгийн Засаг даргын Тамгын газрын 1 байр, Их суварга 505.

Сүхбаатар сум, Сэлэнгэ аймаг, 43081

Утас: Факс: 7036-2223, Цахим шуудан: azdtg@selenge.gov.mn

Цахим хуудас: www.selenge.gov.mn

2024.01.11 № 01/41

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАРТ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний газар, хэлтэс, албад, сум, орон нутгийн хэмжээнд иргэдээс гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн 2023 оны жилийн эцсийн тайланг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт \_\_\_\_\_ хуудастай.



430800053

## ТАНИЛЦУУЛГА

2024-1-22

2023 оны жилийн эцсийн иргэдээс төрийн  
байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан  
өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тухай

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Засгийн газрын 2005 оны “Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай” 67 дугаар тогтоолын хүрээнд Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, 17 сумдын Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 23 газар, хэлтэс, агентлаг, албан тушаалтанд 2023 оны жилийн эцсийн иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээг нэгтгэн танилцуулж байна.

2023 онд аймгийн хэмжээнд иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд нийт **3555** иргэн хандаж санал, хүсэлт, өргөдөл, гомдол гаргаснаас **3459** иргэний өргөдлийг шийдвэрлэж хариу өгсөн нь **97,3** хувийн үзүүлэлттэй байна. Өргөдөл, гомдлыг ирүүлсэн агуулгаар нь авч үзвэл 2623 буюу 73,8 хувь нь хүсэлт, 106 буюу 3 хувь нь санал, 751 буюу 21,1 хувь нь гомдол, 75 буюу 2,1 хувь нь мэдэгдэл байна.

Тайлант хугацаанд иргэдээс ирсэн өргөдөл, гомдолд иргэдээс дэмжлэг хүссэн, нийгмийн хамгааллын чиглэл болон ажилд орох хүсэлт, дэд бүтэц хүрээлэн буй орчин байгаль орчны чиглэлийн хүсэлтууд дийлэнх хувийг эзлэж байна.

Өргөдөл гомдлыг шуурхай шийдвэрлэх ажлын хүрээнд Сүхбаатар, Мандал, Алтанбулаг сумдын зарим багууд болон Жавхлант сумадад “Таныг сонсъё” арга хэмжээг зохион байгуулж иргэдээс ирсэн өргөдөл гомдлыг шуурхай шийдвэрлэж ажилласан.

Мөн 2023 оны 09 дүгээр сарын 15,16-ны өдрүүдэд Ерөнхий сайдын айлчлалын үеэр иргэдтэй хийсэн уулзалтаас гарсан 34 санал, гомдлыг шийдвэрлэх ажлын төлөвлөгөө гаргаж салбар, нэгжүүд хариуцан ажилласан.

### **Нэг. Иргэдээс аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газарт хандаж гаргасан өргөдөл, гомдлын талаар:**

2023 оны байдлаар иргэдээс аймгийн Засаг дарга, түүний Тамгын газарт хандаж **524** өргөдөл, гомдол ирсэн байна. Үүнээс хуулийн хугацаанд **508** шийдвэрлэсэн нь **96,9** хувийн үзүүлэлттэй байна. Иргэдээс гаргасан өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хэлбэрээр нь авч үзвэл бичгээр 162, аймгийн Засаг даргын Тамгын газрын 7036-1111 утсанд 55, Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах төвийн 1111 утсанд Сэлэнгэ аймагт хамааралтай хуваарилагдаж ирсэн 307 санал хүсэлт, гомдол гарсан байна.

Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах 11-11 төвөөс шилжиж ирсэн өргөдөл, гомдол, саналын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 2022 онд 13.6 байсан бол 2023 онд 12.2 болж буурсан байна.

Өргөдөл, гомдлыг агуулга, зонхилж буй асуудлаар авч үзвэл санхүүгийн дэмжлэг, буцалтгүй тусламж, төрийн үйлчилгээг түргэн шуурхай, хүртээмжтэй байдал, ажилд орохыг хүссэн, газрын харилцаатай холбоотой асуудлууд дийлэнх хувийг эзэлж байна.

**Хоёр. Иргэдээс сумдын Засаг дарга, Засаг даргын  
Тамгын газарт хандаж гаргасан өргөдөл, гомдлын талаар:**

2023 оны байдлаар сумдын Засаг дарга, түүний Тамгын газар, тосгоны Захирагч нарт хандаж **1598** өргөдөл, гомдол гаргасан байна. Үүнээс хуулийн хугацаанд **1534** шийдвэрлэсэн нь **96** хувийн үзүүлэлттэй байна. Иргэдээс гаргасан өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хэлбэрээр нь авч үзвэл бичгээр 1440, цахимаар 48, утсаар 30 ирүүлсэн байна. Ирүүлсэн өргөдөл, гомдлыг агуулга, зонхилж буй асуудлаар авч үзвэл ажилд орохыг хүссэн, санхүүгийн дэмжлэг хүссэн, газрын харилцаа, нийгмийн халамжийн үйл ажиллагаатай холбоотой асуудлууд дийлэнх хувийг эзэлж байна. Мөн аймгийн хэмжээнд 7,8 дугаар саруудад их хэмжээний аадар бороо орсны улмаас үеэрт автсан айлуудад хохирол барагдуулж хашаа, байшин хүссэн өргөдөл гомдлын шийдвэрлэлт орсон. Төрийн үйлчилгээ үзүүлэхтэй холбогдуулан бүрдүүлэх материалын бүрдүүлбэр болох өргөдөл, хүсэлтүүдийг тайланд тусгасан сумдын тайланг буцааж засварлуулсан.

**Гурав. Иргэдээс хэлтэс, агентлаг, байгууллагуудад хандаж  
гаргасан өргөдөл, гомдлын талаар:**

2023 онд иргэдээс хэлтэс, агентлаг, байгууллагуудад хандаж **1043** өргөдөл, гомдол гаргасан байна. Үүнээс хуулийн хугацаанд **1181** шийдвэрлэсэн нь **98.6** хувийн үзүүлэлттэй байна. Иргэдээс гаргасан өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хэлбэрээр нь авч үзвэл бичгээр 997, цахимаар 100, утсаар 47 ирүүлсэн байна. Ирүүлсэн өргөдөл, гомдлыг агуулга, зонхилж буй асуудлаар авч үзвэл ажилд орохыг хүссэн, газрын харилцаатай холбоотой, дэмжлэг хүссэн асуудлууд дийлэнх хувийг эзэлж байна.





## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 01 сарын 22 өдөр

Дугаар 02

Сүхбаатар

Аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралдаан 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 11:00 цагт Засаг даргын Тамгын газрын хүндэтгэлийн танхимд болов. Зөвлөлийн хуралд аймгийн Засаг дарга Н.Лхагвадорж, аймгийн Засаг даргын орлогч Ж.Сайнцог, Засаг даргын Тамгын газрын дарга Θ.Сувдаа, Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга Д.Хишигбат, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Я.Мөрөн, Нийгмийн бодлогын хэлтсийн дарга Б.Оюун, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга П.Эрдэнэсайхан, Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Төгөлдөр, Цэргийн штабын дарга Б.Энхболд нар оролцов.

### ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн 2023 оны 3 дугаар улирлын тайланг Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэх тухай

Мэдээллийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга Д.Хишигбат танилцуулав.

### СОНССОН НЬ:

**Д.Хишигбат:** Тайланг гаргахдаа “Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2005 оны 67 дугаар тогтоолын хүрээнд гаргасан. Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2014 оны ХЭГ/548 тоот албан бичгийн хавсралт дахь хүснэгтүүдээр тайланг гаргахад аймгийн хэмжээнд 2023 оны 9 сарын байдлаар 2855 иргэн хандаж санал, хүсэлт, өргөдөл, гомдол гаргаснаас 2741 иргэний өргөдлийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж хариу өгсөн нь 96,0 хувийн шийдвэрлэлттэй байна.

Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайланг гаргахад аймгийн хэмжээнд 2021 онд 5471, 2022 онд 3522, 2023 онд 3555 өргөдөл, гомдол ирснийг 2021 онд 93.6, 2022 онд 97.0, 2023 онд 97.3 хувьтай тус тус шийдвэрлэсэн.

Тайлант хугацаанд иргэдээс ирсэн өргөдөл, гомдолд иргэдийн төрсний бүртгэл, регистрийн дугаарын зөрчил, цахим үнэмлэх, гадаад паспорт сунгуулах шилжилт хөдөлгөөн болон бусад газрын харилцаа, нийгмийн халамжид хамрагдах, тусламж, дэмжлэг хүссэн, хөдөлмөр эрхлэлт, эрүүл мэндийн үйлчилгээтэй холбоотой асуудлаар гаргасан хүсэлт дийлэнх хувийг эзэлж байна.

Аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын зүгээс өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хугацааг хуулийн 30 хоногийг хүлээлгүйгээр шуурхай шийдвэрлэж ажиллах чиглэлийг баримталж ажилласнаар шийдвэрлэлтийн дундаж хугацаа 12 хоног байх зорилтоо ханган ажиллаж байна.

**Θ.Сувдаа:** Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлт сайн байна. Аймгийн Засаг дарга болон Засаг даргын Тамгын газарт хандаж гаргасан өргөдөл, гомдол хэд байгаа вэ?

**Д.Хишигбат:** 2023 оны 9 сарын байдлаар иргэдээс аймгийн Засаг дарга, түүний Тамгын газарт хандаж **419** өргөдөл, гомдол ирсэн байна. Үүнээс хуулийн хугацаанд **387** шийдвэрлэсэн нь **92,4** хувийн үзүүлэлттэй байна. Иргэдээс гаргасан өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хэлбэрээр нь авч үзвэл бичгээр **127**, аймгийн Засаг даргын Тамгын газрын **7036-1111** утсанд **37**, Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах төвийн **1111** утсанд Сэлэнгэ аймагт хамааралтай хуваарилагдаж ирсэн **255** санал хүсэлт, гомдол гарсан байна.

**Н.Лхагвадорж:** Иргэдээс төрийн байгууллагад ямар асуудлаар өргөдөл, гомдол гаргаж байна?

**Д.Хишигбат:** Ихэнх хувийг газрын харилцаа, байгаль орчин, амьдрах орчин, дэд бүтэц, төрийн үйлчилгээний хүртээмжтэй байдал, чанар, дэмжлэг, тусlamж хүссэн өргөдөл гомдлууд эзэлж байна.

### ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн 2023 оны 3 дугаар улирлын тайланг Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж, цаашид иргэдийн өргөдөл гомдлыг хуулийн хугацаа хүлээлгүйгээр түргэн, шуурхай шийдвэрлэж, төрийн албан хаагчийн ёс зүй, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах, хүртээмжтэй холбоотой гомдол гаргуулахгүй байх талаар төр, төсвийн бүх шатны байгууллагуудад чиглэл өгөхөөр шийдвэрлэлээ.

